

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Ажиллагсдад олгох хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202104511**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “Ажиллагсдад олгох хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: **2019, 2020 онд гүйцэтгэсэн борлуулалтын нийт хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.**

2019, 2020 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитын байгууллагын дүгнэлтийн эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хувийг ирүүлэх бөгөөд санхүүгийн тайланг бүгдийг ирүүлэх шаардлагагүй.

Тендерийн хамт 2,150,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 09:00 цагаас өмнө цахимаар www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД-22, Энхтайваны өргөн чөлөө – 98, 406 тоот өрөө, утас: 450060 + 115

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ